



“Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ХХК
Дархан-Уул аймаг, Дархан сум, 16-р баг,
Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр ХХК,
206 тоот өрөө
Утас/факс: 7509-0044
Вэбсайт: www.dmp.mn

**“Дарханы Төмөрлөгийн Үйлдвэр” ХХК-д шаардлагатай
шууд худалдан авалтын зар**

Батлагдсан төсөвт өртөг: 19,500,000 төгрөг

2025.11.24

№	Бараа ажил, үйлчилгээний нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Үзүүлэлт
1	Зөөврийн макет	шир	1.0	1 м-с багагүй, диаметртэй дугуй хэлбэртэй макет, зөөвөрлөхөд эвдэрч хэмхрэхгүй байхаар бат бөх хийцлэлтэй, нэг эсвэл хэд хэдэн хэсгээс бүрдсэн, салгаж угсрахад хялбар байх.

**“ГАН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ЦОГЦОЛБОР” ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА ЗӨӨВРИЙН
ЗОРИУЛАЛТТАЙ МАКЕТ ХИЙХ АЖЛЫН ДААЛГАВАР**

Макет хийх ажил:	Жилийн 1 сая тн ган цувимал бүтээгдэхүүн үйлдвэрлэх “Ган үйлдвэрлэлийн цогцолбор”- т багтах үндсэн болон туслах үйлдвэрүүд хотхоны ерөнхий төлөвлөлт судалгаа хийх.
Захиалагч байгууллага:	“Дарханы Төмөрлөгийн үйлдвэр” ХХК
Ажлын даалгавар өгөх үндэслэл:	“Ган үйлдвэрлэлийн цогцолбор”- т багтах үндсэн болон туслах 5-аас доошгүй үйлдвэрүүд болон ажилчдын хотхоны төлөвлөлт судалгаа хийх
Судалгааны ажлын зорилго:	✓ Уг макетыг үндэслэж төслийн ажлын ерөнхий төлөвлөлт ач холбогдлын талаар тайлбар мэдээлэл олгох
Гурван хэмжээст Макетны ажлын үр дүн:	✓ Үзүүлэн, Сургалт, Танин мэдэхүйн мэдээлэл олгох ерөнхий төлөвлөлтийн иж бүрэн гурван хэмжээст макет
Гурван хэмжээст Макет гүйцэтгэлийн ажлын арга зүй, аргачлал, дэс дараалал:	<u>Ажлын бэлтгэл</u> Төмрийн хүдрээс ган үйлдвэрлэх технологийн судалгаа хийх Үндсэн гангийн үйлдвэр болон дайвар бүтээгдэхүүн болох халуун хий, шаар тэдгээрийг боловсруулах үйлдвэрүүдийн судалгааг үндэслэн макетны хийцлэлийн материал бэлтгэл. <u>Гүйцэтгэх үе шат:</u> Гүйцэтгэлийн ажлын хүрээнд судлагдсан үйлдвэрүүдийн технологийн дамжлагын дагуу макетийн ерөнхий төлөвлөлт хийх. Үндсэн болон дайвар бүтээгдэхүүн болон хот төлөвлөлтөд дараах хэсгүүдийн 3D printer, CNC , LASER ENGRAVE хийж 20,000с доошгүй нарийвчилсан эд ангиас бүрдсэн байх. Үүнд: Үндсэн үйлдвэр: 1. Коксын үйлдвэр

	2. Аргалжийн үйлдвэр 3. Домен зуух 4. Хүчилтөрөгчийн конвертор 5. Цутгах цех 6. Цувих цех Дайвар үйлдвэр: 1. Шаар, Цементийн үйлдвэр 2. Хийн турбин 3. Цахилгаан станц 4. Кокс-химийн үйлдвэр 5. Жижиг дунд үйлдвэр Хот төлөвлөлт: 1. Ажилчдын орон сууц 2. Эмнэлэг 3. Сургууль 4. Цэцэрлэг 5. Спорт заал 6. Цэцэрлэгт хүрээлэн <u>Масштаб тодорхойлох:</u> Ерөнхий төлөвлөлтийн дагуу 1 сая тн хүчин чадалтай ган үйлдвэрлэлийг дагасан үндсэн болон дайвар бүтээгдэхүүний үйлдвэрүүдийн хүчин чадал, барилга байгууламжууд тус бүрийн хэмжээг тооцож масштаб тодорхойлно. Уг масштаб нь 1-2 метр радиустай тойрог байх бөгөөд ажлын зураг нь макет хэвлэх 3D принтерт таних програмаар бэлтгэнэ. <u>Зөөврийн зориулалттай макетны суурь хийцийн ерөнхий шаардлага:</u> 1,5 метрээс багагүй диаметр бүхий нерж төмөр материал ашиглан Төмөрлөгийн үйлдвэрлэлийн чухал шат дамжлагыг дүрсэлсэн хийцлэлтэй байх (Ган хайлах боловсруулах үеийн халах хөрөх шат дамжлага хайлмалын цацраг гэх мэт). Гураваас доошгүй хэсэгээс бүрдэх ба зөөх угсрах үед ашиглахад хялбар байдлаар төлөвлөж зураг төлөвлөгөөг холбогдох ажилтантай зөвшилцөн загвар гарган хийх.
Ажил гүйцэтгэх хугацаа:	✓ Захиалагч, Гүйцэтгэгч талууд гэрээнд гарын үсэг зурснаас эхлэн хуанлийн 30 хоногт багтаан гүйцэтгэнэ.
Гүйцэтгэгч талд тавигдах шаардлага:	✓ Тоног төхөөрөмжийн нөөц ажлын байр 3D printer Co2 Laser cutter Cnc machine ✓ Энэ чиглэлийн ажил гүйцэтгэж байсан туршлагатай байна

Жич:

- **Урьдчилгаа төлбөр олгохгүй**
- **Төлбөрийг бараа нийлүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор төлнө.**
- **Үйл ажиллагааны чиглэл нь төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа /Гадаад худалдаа/ байх.**

Бүрдүүлж ирэх материал:

- **Албан бичиг /Үнийн санал, нийлүүлэх хугацаа, төлбөрийн нөхцөлийг дурдсан байх/**
- **Байгууллагын гэрчилгээ, НӨАТ-ын гэрчилгээ, Татварын өргүй тухай тодорхойлолт**
- **Нийлүүлэх барааны үзүүлэлт, танилцуулга, бусад нотлох баримт**
- **Хариуцах этгээдийн итгэмжлэл, холбогдох мэйл, утасны дугаар**

Үнийн санал хүлээн авах сүүлийн хугацаа:
2025 оны 11 дүгээр сарын 26-ны өдрийн 17 цаг 00 минут хүртэл

Шууд худалдан авалттай холбоотой тодруулга
болон үнийн санал хүлээн авах ажилтны
холбогдох хаяг: Худалдан авалтын хэлтэс
/procurement@dmp.mn/
Утас: 7509-0044